# ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 16 өдөр Дугаар А/345 Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах алба,
мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь заалт, 33 дугаар зүйл, Шадар сайдын 2025 оны “Журам батлах тухай” 15 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах улсын алба, тэдгээрийн түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, ажиллах нийтлэг журам, улсын албаны штабын бүтцийн загвар гарсантай холбогдуулан аймгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулсугай.

2.“Гамшгаас хамгаалах алба, тэдгээрийг түшиглэн ажиллах төрийн байгууллагын жагсаалт, чиг үүргийг нэгдүгээр, “Гамшгаас хамгаалах албаны штабын бүтцийг хоёрдугаар, Гамшгаас хамгаалах орон нутгийн албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги, хүн хүчийг гуравдугаар, Тусгай зориулалтын мэргэжлийн анги, хүн хүчийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлалсугай.

3.Гамшгаас хамгаалах албадын бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг гамшгаас хамгаалах албадын дарга нарт, албадын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ж.Эрдэнэбат)-д тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.АЮУРБУНЬ

D:\My Documents\ Захирамж-2025

231011049

ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠠᠷᠠᠳ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠰᠠᠩᠬᠦ᠋ᠦ ᠶᠢᠨ ᠶᠠᠮᠤ

᠒᠐᠒᠐ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠖ ᠡᠳᠦᠷ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠓/᠓᠒᠒

[illegible]

ᠪᠦᠭᠦᠳᠡ ᠨᠠᠶᠢᠷᠠᠮᠳᠠᠬᠤ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠠᠷᠠᠳ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠰᠠᠩᠬᠦ᠋ᠦ ᠶᠢᠨ ᠶᠠᠮᠤ [illegible]

[illegible]

ᠰᠠᠩᠬᠦ᠋ᠦ ᠶᠢᠨ ᠶᠠᠮᠤ [illegible]

Аймгийн Засаг даргын
2025 оны ...06... дугаар сарын ...16... –ны
...А/345... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН НУТГИЙН АЛБА, ТЭДГЭЭРИЙГ ТҮШИГЛЭН АЖИЛЛАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ, АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

| № | Орон нутгийн албаны нэр | Орон нутгийн албаны дарга | Түшиглэн ажиллах байгууллага | Чиг үүрэг |
|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн алба | Байгаль орчны газрын дарга | Байгаль орчны газар,<br><br>Ус, цаг уур орчны шинжилгээний төв,<br><br>Хэрлэн голын сав газрын захиргаа<br>Зооноз ӨСТ | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэх<br>- Байгаль, цаг агаарын гамшигт болон аюулт үзэгдлийн тухай урьдчилсан мэдээ, мэдээлэл, сансрын хиймэл дагуулын үзэгдлийн зураглал гаргах, олон нийт, иргэдэд мэдээлэх<br>- Байгаль, цаг агаарын гаралтай гамшигт болон аюулт үзэгдлийн нөлөөллийн үнэлгээг тухай бүр хийж урьдчилан сэргийлэх мэдээллээр хангах<br>- Гамшгийн үед химийн хорт болон аюултай бодис алдагдах, аюул учрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих<br>- Гамшгийн үед химийн хорт болон аюултай хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд, хяналт тавих<br>- Химийн хорт болон аюултай бодисоос үүдэлтэй ослын хор уршгийг арилгах хариу арга хэмжээг удирдлага зохион байгуулалтаар хангах, шаардлагатай нөөц бүрдүүлж бэлэн байдлыг хангах<br>- Усны нөөц, уст цэгийн ашиглалтад хяналт тавих<br>- Байгаль орчны бохирдол, ойн хөнөөлт шавж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх ажлыг зохион байгуулах<br>- Бусад Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах;<br>- Холбогдох байгууллагуудтай хамтран ус, хөрс, агаар дахь ионжуулагч цацрагийн хэмжээ хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлан тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хяналт тавих, мэдээлэх;<br>- Холбогдох байгууллагуудтай хамтран орчны цацрагийн дэвсгэр түвшний өөрчлөлт, агаар, хөрс, ус дахь цацрагийн бохирдолт болон өөрчлөлтөд хяналт тавих, мэдээллээр хангах; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | - Цацрагийн ослын тухай мэдээг орон нутаг болон олон улсын байгууллагаас хүлээн авч мэдээлэл солилцох;<br>- Цацрагийн ослын хохирлын үнэлгээ тогтооход дэмжлэг үзүүлэх;<br>- Цацрагийн ослын голомтод зохион байгуулж буй үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх;<br>- Цацрагийн ослын хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, шаардлагатай нөөц бүрдүүлэх;<br>- Холбогдох байгууллагуудтай хамтран цөмийн болон цацрагийн бохирдол, тунгийн хэмжээг тогтоох, бохирдлыг арилгах, хоргүйжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах; |
| 2 | Боловсролын улсын алба | Боловсролын газрын дарга | Боловсролын газар, аймгийн Политехник коллеж | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Гамшгийн үед хүүхэд хамгааллыг хэрэгжүүлэх<br>- Гамшгийн үед салбарын хэмжээнд тогтвортой байдлыг хангах<br>- Бүх шатны боловсролын байгууллагын дотуур байранд амьдарч буй суралцагчдын эрүүл мэнд, хоол хүнс, аюулгүй байдал, хүүхэд хамгааллын асуудалд анхаарах, цахим сургалт, мэдээллийг хүртээмжтэй явуулах<br>- Гамшиг ослын болон бусад шаардлагатай тохиолдолд боловсролын байгууллагын барилга байгууламжийг түр орон байраар ашиглах боломжийг бүрдүүлэх<br>- Гамшиг ослын үед түр орон байраар хангагдсан иргэдийн сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулж сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах<br>Бусад |
| 3 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын алба | Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын дарга | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар,<br><br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Гамшгийн үед хүүхдийн аюулгүй байдлыг хангах, жендерээс үүдэлтэй хүчирхийллээс хамгаалах ажлыг зохион байгуулах<br>- Эмзэг бүлгийн болон эцэг эхийн хараа хяналтгүй хүүхдүүдийн судалгаа гаргах, шаардлагатай бүх талын тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах<br>- Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед эхний ээлжид хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж үзүүлэх<br>- Гамшгийн үед олон нийтэд нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Нийгмийн даатгалын газар | - Нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд (иргэний бүртгэл, мэдээллийн бүлэгт) дэмжлэг үзүүлэх<br>Бусад |
| 4 | Зам, тээврийн алба | Хэнтий аймгийн Авто тээврийн төвийн дарга | Автотээврийн үндэсний төв,<br><br>Харгүй "АЗЗА" ТӨХК,<br><br>"Өндөрхаан" нисэх буудал | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Гамшгийн үед аврах ажиллагаа зохион байгуулах, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах тээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтлөх<br>- Нүүлгэн шилжүүлэлтийн үед шаардлагатай техник, тээврийн хэрэгслээр хангах<br>- Авто зам, замын байгууламж, төмөр замын дэд бүтэц, нисэх буудалд учирсан хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх<br>- Иргэний агаар, төмөр зам, усан зам болон нийтийн тээврийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах<br>- Олон улсын болон орон нутгийн нисэх буудал, агаарын навигацийн үйлчилгээний хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, зохицуулах<br>- Улс, хот хоорондын авто замын чиглэлийг өөрчлөх, хаах арга хэмжээг тухайн нөхцөл байдалд нийцүүлж авах<br>- Шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах<br>- Гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах<br>- Гамшиг ослын үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх, тээвэрлэх, нөөц зам, гүүрний судалгаа гаргах, нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал тээвэрлэн хүргэх, гамшгийн голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээг үзүүлэх<br>Бусад |
| 5 | Санхүүгийн алба | Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга | Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс, татварын хэлтэс орон нутгийн өмчийн газар, санхүү хяналт аудитын алба | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах чиглэлээр хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх, төрөл бүрийн хангалтын нөөцийг холбогдох норм, стандартын дагуу бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, сэлгэх ажлыг зохион байгуулах.<br>- Хохирол хэрэгцээний үнэлгээнд үндэслэн шаардлагатай мөнгөн хөрөнгө зардлыг тооцох, шийдвэрлүүлэх, хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн ангитай хамтран нөөцийн бараа бүтээгдэхүүнийг хуваарилах ажлыг зохион байгуулах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Бусад |
| 6 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын алба | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Хот, тосгон, барилга байгууламж барих, өргөтгөх, зураг төсөлд гамшгаас хамгаалах шаардлагыг тусгуулж тэдгээрийн угсралтын явцад хяналт тавьж ажиллах<br>- Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд барилгын насжилт, барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд үнэлгээ, паспортжуулалт хийх, хүн амд учирч болзошгүй эрсдэлийг тооцоолох, зардлыг шийдвэрлүүлэх<br>- Гамшгаас хот суурин, барилга, холбооны байгууламж, зам гүүр, тээврийн хэрэгсэлд үүсэх хөнөөлийн зэрэг, хүн амд учирч болзошгүй хохирол, аврах ажлын багтаамжийг тооцоолж, инженерийн хангалтыг зохион байгуулах<br>- Гамшгийн үед ашиглах барилга байгууламж, зам гүүр, машин механизм, тээврийн хэрэгслийн байршил, хүчин чадлын судалгаа гаргаж тэдгээрийг дайчлан ашиглах боломжийг бүрдүүлэх, бэлэн байдлыг тодорхойлох<br>- Гамшгийн голомтод үйл ажиллагаа зохион байгуулах инженерийн хангалтын арга хэмжээг зохион байгуулах<br>- Гамшгийн үед шаардлагатай мэдээлэл, хот байгуулалт, барилга байгууламжийн зураг, төслөөр хангах<br>- Бүх төрлийн байр зүйн зургаар хангах<br>- Инженерийн шугам сүлжээ, ундны усны эх үүсвэрийг хамгаалж, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх<br>- Үерийн хамгаалалт, далан сувгийн хэвийн ажиллагааг хангуулах<br>- Гамшгийн үеийн геодезийн хэмжилтийн ажил гүйцэтгэх багаж, тоног төхөөрөмжөөр хангах<br>- Шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх<br>- Гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах<br>- Гамшгийн үед орон гэргүй болсон иргэдийг түр орон байраар хангах, барилга байгууламжийн эвдрэл гэмтлийн үед ажиллах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.<br>- Газарзүйн мэдээллийн системийг хөгжүүлэх, зайнаас тандан судлах, мэдээллээр хангах,<br>- Гамшгийн үед байр зүйн зураг бэлтгэх, зургаар хангах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>Бусад |
| 7 | Хүнс, хөдөө аж ахуйн алба | Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, | Хүнс, хөдөө аж ахуйн газар, мал эмнэлгийн газар | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг аймаг, нийслэл, сум, дүүргээр улсын хэмжээнд тогтмол тодотгож, дүн шинжилгээ хийх<br>- Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортыг саадгүй нэвтрүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх<br>- Хот хоорондын болон хот доторх хүнсний бүтээгдэхүүний тээврийн үйл ажиллагааг хүнсний аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн удирдлага, зохион байгуулалтаар хангах<br>- Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр болон түгээх цэгийн үйл ажиллагааны эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй байдал, ус хангамжийн тасралтгүй байдлыг хангах<br>- Хүнсний бүтээгдэхүүний хангалт, тэдгээрийн тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, хяналт тавих<br>- Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэдгээрийн нутагшсан сорт, бэлчээрийн ургамлын хортон шавж, биологийн өвчлөлөөс хамгаалах<br>- Гамшгийн үед ашиглах усны нөөцийг бүрдүүлэх, нөхөн сэлбэх, хадгалах, хамгаалах<br>- Бэлчээрийн зохион байгуулалт, мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийн талаар нэгдсэн мэдээллээр хангах, зудын аюулаас мал сүргийг хамгаалах арга хэмжээг удирдан зохион байгуулах<br>- Гамшгийн нөхцөл байдалтай холбоотой асуудлыг дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх<br>- Шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх<br>- Бэлчээрийн болон таримал ургамал, ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих<br>- Зуд, ган, бэлчээрийн талхагдал, ургац алдалтын үед хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах<br>- Гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах<br>- Нэрвэгдэгсдэд болон ослын голомтод үүрэг гүйцэтгэж буй гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурынхныг цэвэр ус, хоол хүнсээр хангах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | - Хөнгөн үйлдвэрийн салбарын осол, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах<br>Бусад |
| 8 | Мэдээлэл харилцаа холбооны алба | “Монголын цахилгаан холбоо” ХК-ний захирал | “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК,<br><br>“Монголын цахилгаан холбоо” ХК,<br><br>Юнител ХХК,<br>Жи мобайл ХХК,<br>Скайтел ХХК,<br>Юнивишн ХХК,<br>Мобиком ХХК | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиог төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хүн амд зарлан мэдээлэх ажлыг шуурхай зохион байгуулах<br>- Улсын мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг нөхөн сэргээх, техник хэрэгслийг бэлэн байдлыг хангах, гэмтэл саатлыг арилгах, нөхөн сэргээх, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, хэвийн найдвартай ажиллагаагаар хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх<br>- Гамшгийн үед харилцаа холбоог бүх төрлийн сувгаар зохион байгуулж, мэдээ мэдээллийг саадгүй дамжуулах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ дэд бүтэц, тоног төхөөрөмжийн тасалдалгүй, найдвартай ажиллагааг хангах мэдээллийн технологийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх, оновчтой шийдлийг зохион байгуулах<br>- Гамшгийн үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн систем, сүлжээг хууль тогтоомжийн дагуу дайчлах, хэвийн найдвартай ажиллагаагаар хангах<br>- Гамшгийн голомтод холбоо зохион байгуулах, бэлэн байлгах<br>- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь дэд бүтэц, түүний нөөц сувагчлал, нөхөн хангалтыг хийж бэлэн байдлыг хангах<br>Гамшгийн үеийн удирдлага зохион байгуулалтын үед нөхцөл байдлын мэдээлэл бүрдүүлэх зорилгоор мэдээллийн системийг хөгжүүлэх, холбох, мэдээллийн санг бүрдүүлэх, нөөцлөх |
| 9 | Эрүүл мэндийн алба | Эрүүл мэндийн газрын дарга | Эрүүл мэндийн газар,<br><br>Аймгийн нэгдсэн эмнэлэг<br><br>Улаан загалмайн хороо | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах Хүний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагуудтай харилцан ажиллах<br>- Гамшгийн үед нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх<br>- Нэрвэгдэгсэд болон хүний гоц халдварт өвчнөөр өвчилсөн иргэдийг эмчлэх, эмнэлэг дэлгэх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүнээр хангах<br>- Алан хядах ажиллагаанд ашиглаж болзошгүй биологийн хэрэгслийн талаарх мэдээлэл, учрах хохирлын үнэлгээг хийх<br>- Олон улсын хөл хориот өвчний онош тогтоох<br>- Вакцинжуулалт, ариутгал, халдваргүйтгэл хийх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | - Гамшгийн нөхцөл байдалтай холбоотой асуудлыг дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх<br>- Нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах<br>- Эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлаа хангах, хангалт зохион байгуулах<br>- Гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах<br>Бусад |
| 10 | Сурталчилгааны алба | АЗДТГ-ын хэвлэл мэдээллийн алба | АЗДТГ-ын хэвлэл мэдээллийн алба,<br>“Өндөрхаан” телевиз,<br>“Хэнтий мэдээ” сонин,<br>“ЖИ ТАЙМ” сайт<br>“Аруухан” сайт | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Гамшгийн тухай зарлан мэдээллийн болон сэрэмжлүүлэх дохио, мэдээллий дамжуулах арга хэмжээг зохион байгуулах,<br>- Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээний явц, байдлын тухай мэдээ, мэдээллийг хүн амд хүргэх Улсын албадаас гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний тухай бэлтгэсэн ухуулга сурталчилгааг олон нийтэд шуурхай хүргэх<br>- Гамшгийн онцгой нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол шуурхай, хүртээмжтэй, дэлгэрэнгүй мэдээлэх<br>- Гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах<br>Бусад |
| 11 | Эрчим хүчний алба | Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга | БЗӨБЦТСС-ын Цахилгаан түгээх сүлжээ салбар, Хэнтий Ус ХК, Хэнтий цахилгаан дамжуулах хэсэг | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Гамшгийн үед онц чухал объектуудыг эрчим хүчээр тасралтгүй хангах<br>- Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийг техникийн үүдэлтэй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах<br>- Эрчим хүчний зохицуулалт, цахилгаан эрчим хүчний хангалтад хяналт тавих, хязгаарлах, түдгэлзүүлэх<br>- Нэмэлт болон нөөц эрчим хүчээр хангах<br>- Шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх, Гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах<br>Бусад |
| 12 | Хэв журам сахиулах алба | Цагдаагийн газрын дарга | Цагдаагийн газар, | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Гамшгийн үед нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Дотоодын цэргийн 830-р тусгай салбар | - Голомтын бүсэд эргүүл, постуудыг гарган аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох<br>- Аврах хүч хэрэгслийг голомтод саадгүй нэвтрүүлэх<br>- Гамшигт нэрвэгдэгсдийн талаарх мэдээлэл цуглуулах, сураггүй алга бологсдыг шалган тогтоох, эрэн сурвалжлах, нас барагчдыг таниулах, нэр хаягийг тогтоох ажлыг зохион байгуулах<br>- Улсын онц чухал объектуудын харуул хамгаалалтыг зохион байгуулах<br>- Иргэдийн эрүүл мэнд, амь нас, төр, аж ахуйн нэгж байгууллага иргэдийн, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг гэмт халдлагаас хамгаалах<br>- Гамшгийн голомт болон хорио цээрийн бүсэд хамгаалалт зохион байгуулах,<br>- Гамшгийн голомтод гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах, шалтгаан нөхцөлийг тогтоох<br>- Гамшгийн голомт болон хорио цээрийн бүсэд зорчих тусгай зориулалтын техник хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, шалган нэвтрүүлэх Шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хангалт хийх<br>- Гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах, мэдээллээр хангах<br>Бусад |
| 13 | Мал эмнэлгийн алба | Мал эмнэлгийн газрын дарга | Мал эмнэлгийн газар | - Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй ажлын талаар мэдээлэх,<br>- Мал, амьтны халдварт өвчний голомтыг устгах арга хэмжээг мэргэжлийн удирдлагаар хангах,<br>- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, голомтод хорио цээр, эрүүл ахуйн дэглэмийг хэрэгжүүлэх, шаардагдах нөөцийг бүрдүүлэх, ДМАЭМБ-ын дүрмийн дагуу мэдээлэх,<br>- Вакцинжуулалт, ариутгал, халдваргүйтгэл, устгал хийх<br>Бусад |

Аймгийн Засаг даргын
2025 оны 06 дугаар сарын 16 –ны
А/1345 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

# ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАНЫ ШТАБЫН БҮТЭЦ



Аймгийн Засаг даргын
2025 оны 06 дугаар сарын 16 –ны
А/345 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

# ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН НУТГИЙН АЛБАНЫ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН АНГИ, ХҮН ХҮЧ

| № | Мэргэжлийн ангийн нэр | Бүлэг | Хэсэг | Чиг үүрэг | Түшиглэн ажиллах байгууллага |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги **(хүний тоо-20)** | Усны сан бүхий газар, уст цэг, усан хангамжийн бүлэг **(хүний тоо-10)** | Усны сан бүхий газар, уст цэгийг хамгаалах хэсэг **(хүний тоо-10)** | Усны эх ундарга, усны сан бүхий газар, уст цэгийн бохирдолтод шинжилгээ хийх, усыг бохирдох, хор, халдвараас хамгаалах, ариутгал хийх, шинээр худаг ус гаргах, ус тээвэрлэх, түгээх, харуул хамгаалалтад авах, үер усны аюулаас хамгаалах | Байгаль орчны газар, Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Хэрлэн голын сав газрын захиргаа Зооноз ӨСТ |
| | | Цацраг, хими, биологийн хариу арга хэмжээ, хяналтын бүлэг **(хүний тоо-15)** | Химийн хэсэг **(хүний тоо-5)** | химийн тандалт явуулах, үнэлэлт өгөх, хяналтыг хэрэгжүүлэх, химийн бодис, аюулыг тодорхойлох, хэмжилт хийх, эрэн хайх, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, саармагжуулах ба идэвхгүйжүүлэх, ариутгал цэвэрлэгээ хийх | |
| | | | Биологийн хэсэг **(хүний тоо-5)** | Биологийн аюулыг тодорхойлох, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх | |
| 2 | Боловсролын улсын албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги **(хүний тоо-30)** | Хүүхэд хамгааллын бүлэг **(хүний тоо-30)** | Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон зайг бий болгох, хүүхэд хамгааллын асуудлаар бусад мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, сургуульд элсэхийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн боловсролыг тасралтгүй явуулах ажлыг зохион байгуулах | | Боловсролын газар, аймгийн Политехник коллеж |
| 3 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги **(хүний тоо-21)** | Нийгмийн хамгааллын бүлэг **(хүний тоо-21)** | Хүүхэд хамгааллын хэсэг **(хүний тоо-9)** | Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон зайг бий болгох, хүүхэд хамгааллын асуудлаар бусад мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, сургуульд элсэхийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн боловсролыг тасралтгүй явуулах ажлыг зохион байгуулах | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Нийгмийн даатгалын газар |
| | | | Өндөр настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгааллын хэсэг **(хүний тоо-12)** | Гамшиг, ослын үед өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн асуудлыг зохион байгуулах, голомтын бүсээс эхний ээлжинд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Зам, тээврийн албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги **(хүний тоо-30)** | Зам, гүүр засварын бүлэг **(хүний тоо-5)** | Зам, гүүр засварын хэсэг **(хүний тоо-5)** | Гамшгийн үед эвдэрсэн зам, гүүрийг засварлах, нөөц замыг тодорхойлох, гүүр дэлгэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах | Автотээврийн үндэсний төв,<br><br>Харгүй "АЗЗА" ТӨХК,<br><br>"Өндөрхаан" нисэх буудал |
| | | Инженер, техникийн бүлэг **(хүний тоо-5)** | Инженерийн хэсэг **(хүний тоо-2)** | Гамшгийн үед бүх төрлийн инженерийн дэмжлэг үзүүлэх, тооцоолол гаргах | |
| | | | Техникийн хэсэг **(хүний тоо-3)** | Техникийн дэмжлэг, засварын ажлыг гүйцэтгэх, бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн тооцоо судалгаа гаргах, техник хэрэгслээр хангах | |
| | | Зам, гүүрний засварын бүлэг **(хүний тоо-10)** | | Гамшиг, ослын улмаас нурсан, эвдэрсэн зам, гүүр засвар хийх, гарц гаргах, түр гүүр тавих, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх | |
| | | Автотээврийн хангалт бүлэг **(хүний тоо-5)** | Автотээврийн хангалтын хэсэг **(хүний тоо-2)** | Гамшгийн үед автотээврийн хангалтыг зохион байгуулах | |
| | | | Тээврийн хэсэг **(хүний тоо-3)** | Нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал тээвэрлэн хүргэх, гамшиг, ослын голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээ үзүүлэх | |
| | | Нисэх буудлын аюулгүй байдлын бүлэг **(хүний тоо-5)** | Нисэх буудлын аюулгүй байдлын хэсэг **(хүний тоо-2)** | Агаарын хөлгийн хөөрөх, буух үеийн аюулгүй байдлыг хангуулах, гамшиг, ослын үед нислэгийн бүсэд аврах, хор уршгийг арилгах, гал түймрийг унтраах, нислэгийн зурвасыг сэргээн босгох ажлыг зохион байгуулах | |
| | | | Нисэх буудлын зохицуулалтын хэсэг **(хүний тоо-3)** | Гамшгийн үед агаарын хөлгөөр хүн, ачаа тээврийг зохион байгуулах | |
| 5 | Санхүүгийн албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги **(хүний тоо-20)** | Санхүү зохицуулалтын бүлэг **(хүний тоо-5)** | Санхүүгийн хэсэг **(хүний тоо-2)** | Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах чиглэлээр нөөц хөрөнгө бүрдүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн шаардлагатай мөнгөн хөрөнгө, зардлыг тооцох, шийдвэрлүүлэх | Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс, татварын газар, орон нутгийн өмчийн газар, санхүү хяналт аудитын алба |
| | | | Санхүүгийн нөөцийн хэсэг **(хүний тоо-3)** | Гамшиг, ослын үед санхүү, хөрөнгө гаргах, зохицуулалт хийх, зохион байгуулах | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Нөөцийн бараа материал бүрдүүлэх, хүнс,усаар хангах бүлэг **(хүний тоо-15)** | Хүнс, усаар хангах хэсэг **(хүний тоо-3)** | Нэрвэгдэгсэд болон гамшиг, ослын голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг хоол, цэвэр ус, хүнсээр хангах | |
| | | | Дулаан байр, хувцас хангалтын хэсэг **(хүний тоо-3)** | Гамшиг, ослын үед нэрвэгдэгсэд болон аврагч, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа иргэдийн хэрэгцээг тодорхойлж, дулаан хувцас, хөнжил, гудас зэргээр хангах | |
| | | | Нөөц бүрдүүлэх хэсэг **(хүний тоо-3)** | Шаардлагатай хүнсний хангамжийг нөөцийг бүрдүүлэх | |
| | | | Шатахуун, хийн түлш хангалтын хэсэг **(хүний тоо-3)** | Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэж байгаа автомашин, бусад техник хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх, хангах, нөөц бүрдүүлэх | |
| | | | Агуулах,хангамжийн хэсэг **(хүний тоо-3)** | Бараа материал хадгалах агуулах, нөөц хадгалах байр бэлтгэх | |
| 6 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги **(хүний тоо-10)** | Барилга байгууламж, дэд бүтцийн хяналтын бүлэг **(хүний тоо-5)** | | Гамшиг, ослын үед Монгол Улсын хэмжээний онц чухал дэд бүтэц бүхий байгууллагууд болон иргэний барилгуудын хяналтыг зохион байгуулах | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар |
| | | Газарзүйн мэдээллийн сан, зургаар хангах бүлэг **(хүний тоо-5)** | | Газарзүйн мэдээллийн системийг хөгжүүлэх, зайнаас тандан судлах, мэдээллээр хангах,Гамшгийн үед байр зүйн зураг бэлтгэх, зургаар хангах<br>Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах | |
| 7 | Хүнс, хөдөө аж ахуйн албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги **(хүний тоо-5)** | Хөдөө аж ахуйн бүлэг **(хүний тоо-5)** | Ургамал, газар тариалан хамгаалах хэсэг **(хүний тоо-5)** | Химийн хоргүй, байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга технологиор бэлчээрийн болон тариалангийн талбайд хөнөөл учруулдаг хортон шавж, мэрэгчдийн тархалттай тэмцэх, үрийн агуулах, техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдал, стандартын шаардлагыг хангуулах | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| 8 | Мэдээлэл харилцаа холбооны албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги **(хүний тоо-15)** | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүлэг **(хүний тоо-15)** | Мэдээллийн аюулгүй байдлыг хангах бүлэг **(хүний тоо-5)** | Гамшиг, ослын үед Монгол Улсын хэмжээнд онц чухал дэд бүтэц бүхий байгууллагуудын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, учирч болох кибер халдлагаас хамгаалах, хариу арга хэмжээ авах | “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК,<br><br>“Монголын |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Харилцаа холбооны бүлэг **(хүний тоо-5)** | Гамшиг, ослын үед Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, гамшгаас хамгаалах алба, штаб, шуурхай бүлгийн удирдлагын байр, мэргэжлийн ангийг найдвартай харилцаа, холбоогоор хангах, харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтцийг өргөтгөх, гэмтэл саатлыг засварлах, сэргээн босгох, дэвшилтэт технологи нэвтрүүлэх | цахилгаан холбоо" ХК,<br><br>Юнител ХХК,<br>Жи мобайл ХХК,<br>Скайтел ХХК,<br>Юнивишн ХХК,<br>Мобиком ХХК |
| | | | Зарлан мэдээллийн бүлэг **(хүний тоо-5)** | Гамшиг, ослын үед холбогдох албан тушаалтны шийдвэрээр харьяа нутаг дэвсгэрт харилцаа холбооны бүх төрлийн сувгаар зарлан мэдээлэл дамжуулах, зарлан мэдээллэх технологийн шинэчлэлтийг зохион байгуулах | |
| 9 | Эрүүл мэндийн албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги **(хүний тоо-33)** | Эрүүл мэндийн тусламжийн бүлэг **(хүний тоо-28)** | Цус сэлбэх хэсэг **(хүний тоо-8)** | Нэрвэгдэгсдийг цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээгээр хангах, нөөц бүрдүүлэх, тээвэрлэх, хүргэх ажлыг зохион байгуулах | Эрүүл мэндийн газар,<br><br>Аймгийн нэгдсэн эмнэлэг<br><br>Улаан загалмайн хороо |
| | | | Эм, эмнэлгийн хэрэгслээр хангах хэсэг **(хүний тоо-8)** | Гамшиг, ослын үед хээрийн эмнэлэг болон яаралтай тусламжийн хэсгийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх, хээрийн нөхцөлд хөдөлгөөнт эмийн сан ажиллуулах | |
| | | | Зоонозын өвчинтэй тэмцэх хэсэг **(хүний тоо-5)** | Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх, голомтыг цомхотгож хор уршгийг арилгах зорилгоор эмчлэн тусгаарлах, хавьтлыг тогтоож хяналтад авах, ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг хариу арга хэмжээ авах | |
| | | | Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх хэсэг **(хүний тоо-7)** | Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн анхны тусламж, дэмжлэг үзүүлэх, гамшгийн дараах стрессийг бууруулах, сэтгэл гутралыг багасгах, хүмүүсийн даван туулах итгэл найдварыг сэргээх, бусадтай харилцах, холбоо тогтооход нь туслах<br>Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн эрэн хайх, аврах ажиллагааны багийн гишүүдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх | |
| | | Анхны тусламжийн дэмжлэгийн бүлэг **(хүний тоо-5)** | | Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд анхны тусламж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх | |
| 10 | Сурталчилгааны албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги **(хүний тоо-10)** | Ухуулга, сурталчилгааны дэмжлэгийн бүлэг **(хүний тоо-10)** | | Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулах | АЗДТГ-ын хэвлэл мэдээллийн алба, "Өндөрхаан" телевиз, "Хэнтий мэдээ" |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | сонин,<br>"ЖИ ТАЙМ" сайт<br>"Аруухан" сайт |
| 11 | Эрчим хүчний албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги<br>**(хүний тоо-30)** | Эрчим хүч сэргээх бүлэг<br>**(хүний тоо-30)** | Дулааны шугам сүлжээний засварын хэсэг<br>**(хүний тоо-10)** | Дулаан, эрчим хүчний системийн аюулгүй ажиллагааг хангах, шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг илрүүлэх, засвар үйлчилгээ хийх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх | БЗӨБЦТСС-ын Цахилгаан түгээх сүлжээ салбар, Хэнтий Ус ХК, Хэнтий цахилгаан дамжуулах хэсэг |
| | | | Цахилгаан сүлжээний засварын бүлэг<br>**(хүний тоо-10)** | Гамшиг, ослын үед цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан станц, шугамд гарсан эвдрэл гэмтлийг засварлах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх | |
| | | | Ус хангамж, ариутгах татуургын хэсэг<br>**(хүний тоо-10)** | Цэвэр, бохир усны шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, сэргээн босгох ажил гүйцэтгэх | |
| 12 | Хэв журам сахиулах албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги<br>**(хүний тоо-30)** | Аюулгүй байдлын бүлэг<br>**(хүний тоо-20)** | Тусгай зориулалтын хэсэг<br>**(хүний тоо-10)** | Терроризмтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих, ухуулга, сурталчилгаа хийх | Цагдаагийн газар, Дотоодын цэргийн 830-р тусгай салбар |
| | | | Замын хөдөлгөөн зохицуулах хэсэг<br>**(хүний тоо-10)** | Гамшгийн голомтод тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах, журамлах | |
| | | Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хамгаалах бүлэг<br>**(хүний тоо-10)** | | Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед онц чухал объектуудыг хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ | |
| 13 | Мал эмнэлгийн албаны тусгай зориулалтын мэргэжлийн анги<br>**(хүний тоо-13)** | Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх бүлэг<br>**(хүний тоо-5)** | Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн хэсэг<br>**(хүний тоо-9)** | Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, халдварын голомт дахь мал, амьтанд үзлэг тандалт хийж оношийг тогтоох, тусгаарлах, хязгаарлалт хорио цээрийн дэглэм тогтоох, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу авч хэрэгжүүлэх | Мал эмнэлгийн газар |
| | | | Ариутгал, халдваргүйжүүлэлтийн Хэсэг<br>**(хүний тоо-4)** | Мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, цацраг идэвхт болон химийн хорт бодисоор хордсон талбай, халдварт өвчний голомт, голомтод байсан хүн, техник хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ хийх | |

Аймгийн Засаг даргын
2025 оны 06 дугаар сарын 16 –ны
A/1345 дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

# ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН АНГИ, ХҮН ХҮЧ

| № | Мэргэжлийн ангийн нэр | Бүлэг | Хэсэг | Чиг үүрэг | Түшиглэн ажиллах байгууллага |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тусгай зориулалтын мэргэжлийн анги **(хүний тоо-25)** | Бүртгэл мэдээлэл, статистик судалгааны бүлэг **(хүний тоо-10)** | Иргэний бүртгэл, мэдээллийн хэсэг **(хүний тоо-5)** | Гамшиг, ослын үед иргэний бүртгэл, судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах, хуулийн этгээд, иргэнд шаардлагатай лавлагаа, мэдээлэл гаргаж өгөх, бүртгэх | Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтэс, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв |
| | | | Статистик мэдээллийн хэсэг **(хүний тоо-5)** | Мал амьтан, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж, хүч хэрэгслийн тооцоо болон бүх төрлийн судалгаа гаргах, | |
| | | Олон улсын хүмүүнлэгийн тусламж зохицуулалтын бүлэг **(хүний тоо-10)** | Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн хэсэг **(хүний тоо-5)** | Нэрвэгдэгсдэд холбогдох дүрэм, журмын дагуу дотоодын нөөцөөс хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах | Улаан загалмайн хороо |
| | | | Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн хэсэг **(хүний тоо-5)** | Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах | |
| | | Дэмжлэг үзүүлэх бүлэг **(хүний тоо-5)** | | Гамшгийн үед гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэхээс бусад хүн хүчний дэмжлэг туслалцаа үзүүлэх, суралцаж буй чиглэлээр дэмжлэг үзүүлж оролцох<br>Бараа бүтээгдэхүүн тээвэрлэх, хүргэх, хамгаалалт зохион байгуулахад хүн хүчний дэмжлэг үзүүлэх<br>Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд анхны тусламж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх | Политехник коллеж, БТСГ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Шүүх шинжилгээний хэлтэс, эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Музей, |

**Мэргэжлийн ангийн техник, тоног төхөөрөмжийн хангалтад дараах хэрэгслүүд орно:**

1.Байгууллагын гамшгийн нөөц (ус, хүнс, хувцас, тоног төхөөрөмж);
2.Цацраг, хими, биологийн тандалт, хяналтын багаж хэрэгсэл /цацраг, хими, биологийн чиглэлээр үүрэг гүйцэтгэх бүлэгт/;
3.Хүн нэг, бүрийн хамгаалах хэрэгсэл
4.Хүн нэг бүрийн хээрийн үүргэвч;
5.Голомтын бүс, хязгаарлалтын бүс, эрүүл бүсийн тэмдэг тэмдэглэгээ;
6.Гал унтраах багаж, хэрэгсэл;
7.Инженерийн техник;
8.Цэвэр, бохир ус болон дулааны шугам засварлах багаж, техник хэрэгсэл;
9.Холбоо, зарлан мэдээлэх хэрэгслүүд, чанга яригч;
10.Хээрийн гал тогоо;
11.Гамшгийн үеийн удирдлагын хөдөлгөөнт болон суурин байр (гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн удирдлагыг удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилгоор холбоо, мэдээллийн техник хэрэгсэл, бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон хөдөлгөөн үйлдэх боломжтой болон суурин байрыг хэлнэ);
12.Хээрийн эмнэлгийн байр, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм, ороох боох материал, ариутгалын бодисын нөөц;
13.Гэр, майхан (хоргодох байр);

**Мэргэжлийн анги дараах үндсэн баримт бичгүүдийг хөтөлнө:**

1.Мэргэжлийн ангийг байгуулсан тухай тушаал;
2.Бүх төрлийн судалгаа мэдээлэл;
3.Мэргэжлийн ангийн тактикийн төлөвлөгөө, тодотгол;
4.Мэргэжлийн ангийн зохион байгуулалтын бүдүүвч;
5.Мэргэжлийн ангийн чиг үүрэг, зориулалтыг тусгасан дотоод дүрэм, журам;
6.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам;
7.Бие бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын төлөвлөгөө;
8.Сургалт арга зүйн гарын авлага;
9.Мэргэжлийн ангийн техник, багаж хэрэгслийн нөөц, хангалтын тооцоо;
10.Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, штабын дадлагад оролцсон тухай тэмдэглэл;
11.Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг шалгасан, шалгуулсан тухай тэмдэглэл;
12.Мэргэжлийн ангийн гамшгийн голомтод ажилласан тухай тэмдэглэл;

---oOo---